

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГААС СУМЫН ЗАСАГ ДАРГАТАЙ 2023 ОНД
ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ ЗӨВЛӨМЖ**

Говь-Угтаал сумын ЗДТГ

- Иргэдэд тоон гарын үсэг олгох ажлыг эрчимжүүлэн 100 хувьд хүргэх.
- Авлигын эсрэг үйл ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх.
- Хууль зүйн хүрээнд хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний 3.1 дэх заалтын хэрэгжилтийг гаргахдаа өмнөх оны хэрэгжилтийг дахин хуулж бичсэн.
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээг тогтмол зохион байгуулж, үр дүнг тооцох.
- Албан хаагчдаас “Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт”-ын дагуу баримтыг I улиралд багтаан хүлээн авч хэвшүүлэх.
- Шилэн дансанд мэдээлэл оруулсан байдалд улирал бүр хяналт тавьж, хуулийн хэрэгжилтийг 100 хувь хангах
- Орон нутгийн орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь сар бүр жигд биелүүлэх

Санхүү, төрийн сангийн хэлтэс

- Орон нутгийн орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь сар бүр жигд биелүүлэх
- ТЗУХ**

Тайланг хуваарийн дагуу хугацаандаа ирүүлэх

Хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг бичихдээ тухайн шалгуур үзүүлэлт, хүрэх түвшний хувь, тоотой харьцуулж үзэх хувь, тоог баримтыг бичих

Зарим сумд гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд тусгагдсан заалтуудыг хэрэгжилтийг ирүүлээгүй орхисон

Хэрэгжилтийн үр дүн бичдэггүй, дутуу тайлагнадаг, үг үсгийн алдаатай, найруулга зүй байхгүй, баримт бичгийн стандартыг мөрдөөгүй.

Хэрэгжилт дээрээ тоо бичиж ирүүлдэг.

НБХ

1. Аймгийн “Шатар” хөтөлбөрийг болон “3х3” сагсан бөмбөгийн спортыг орон нутагт хөгжүүлэх чиглэлээр аймгийн Засаг даргын 2023 оны 01/681 тоот албан бичгээр хүргүүлсэн төлөвлөгөөнүүдэд тусгагдсан холбогдох заалтуудыг хэрэгжүүлж ажиллах
2. Уртын дуу, морин хуурын сургалтыг яаралтай зохион байгуулж, 3000 морин хуурч, уртын дуучдын эвент наадамд тус гэрээний хавсралтын дагуу квотоор оролцох
3. Ковид-19 халдварын эсрэг дархлаажуулалтад зорилтот бүлгийн иргэдийг хамруулах
4. Амрах байрыг тохижуулж, эхчүүдэд үйлчилгээ үзүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх
5. Эрүүл мэндийн үйлчилгээнд мобайл технологийн үйлчилгээг хурдтай нэвтрүүлж, үзлэг оношилгоог хийх
6. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын 7 арга хэмжээ төлөвлөснөөс 5 арга хэмжээ огт хэрэгжээгүй байна. Иймд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний биелэлтийг эрчимжүүлж ажиллах
7. Ажилгүй иргэдийн сургалтын хэрэгцээний судалгаанд сумын нийт хэдэн ажилгүй иргэн байгаагаас хэдэн иргэн хамруулсан талаар тодорхой тайлагнах. Ажилд зуучлах болон судалгааны хүрэх түвшинг тухайн сумын хүн амын тооноос хамааран төлөвлөх.

8. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөрийн насны ажилд зуучилсан иргэний мэдээллээ Хөдөлмөр эрхлэлтийн e-job программд оруулж ажиллах /Нотлох баримтыг программаас гаргаж ирүүлэх/
9. Хүн амын халдварт бус өвчлөлийн эрт илрүүлэлтэд Иргэдийн урьдчилан сэргийлэх үзлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлэх
10. 18-аас дээш насны хүн амыг зүрх судасны өвчний эрсдэлийн түвшин тогтоох үзлэгт хамруулах хамрагдалтын хувийг нэмэгдүүлэх
11. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чиглэлээр 2023 онд аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах